БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 02 сарын 21 өдөр Дугаар А/105 Улаанбаатар хот

Урьдчилан сэргийлэх үзлэгт
хамруулах тухай

Монгол Улсын Эрүүл Мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/537 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган ТУШААХ нь:

1. Байгууллагын ажилчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, зохион байгуулах журмыг хавсралтаар баталсугай.

2. Байгууллагын ажилчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, үзлэгийн үр дүнг тооцож эрүүлжүүлэлтийн төлөвлөгөө гарган ажиллах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, ажлын байранд халдварт өртөхөөс сэргийлэх дархлаажуулах, эрүүлжүүлэх ажлыг чанартай зохион байгуулахыг Мэдрэлийн эмч (Б.Цэрэнчимэг)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Чанарын менежер (Д.Дашдэлэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА Х.ГАНБАТ

Багахангай Эрүүл мэндийн төвийн даргын
2024 оны 02 дугаар сарын 21-ны өдрийн
А/05 тушаалын хавсралт

АЖИЛЧДЫГ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГТ ХАМРУУЛАХ
АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

ЗОРИЛГО:

Ажилчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх, халдварт өртөхөөс сэргийлэх, өвчлөлийг эрт үед нь илрүүлж, эмчилгээнд хамруулахад үзлэгийн гол зорилго оршино.

ХАМРАХ ХҮРЭЭ: Ажиллаж байгаа ажилчид, шинээр ажилд орсон ажилчид

ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ:

- Ажилчдын эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах
- Үзлэгийн үр дүнг тооцож эрүүлжүүлэлтийн төлөвлөгөөг боловсруулж батлуулж хэрэгжилтийг ханган ажиллах
- Эрүүлжүүлэлтийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг тооцож, зохион байгуулсан ажлын тайланг байгууллагын удирдлагад танилцуулах.
- Ажилчдад эрүүл мэндийн сургалт зохион байгуулж, мэдлэг, дадлыг олгох
- Ажлын байранд халдвараас сэргийлэх, тархалт хамгийн бага хэмжээнд байлгах аюулгүй ажиллагааг бүрдүүлж ажиллах
- Ажилчдын шаардлагатай дархлаажуулалтад хамруулах
- Халдвар авах эрсдэлт хүчин зүйлд өртсөн тохиолдолд халдвараас сэргийлэх арга хэмжээ авдаг, бүртгэж, тайлагнаж ажиллах

ҮЗЛЭГИЙГ ХЭРХЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ

- 2024 оны 3.9 дүгээр сарын 10-15-ны хооронд ажилчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах.
- Зайлшгүй ажлаас шалтгаалж үзлэгийг хуваарьт өдрөө зохион байгуулан боломжгүй тохиолдолд үзлэг зохион байгуулах хугацааг товлон ажилчдад мэдээллийг хүргэнэ.
- Шинээр ажилд орсон ажилтныг ажилд орсон өдрөөс 3 хоногийн дотор үзлэг шинжилгээнд хамруулсан байна.
- Үзлэгт хамруулсны дараа 7 хоногийн дотор нэгтгэлийг гаргаж, эрүүлжүүлэлтийн төлөвлөгөөг боловсруулан байгууллагын даргаар батлуулах.
- Төлөвлөгөөний биелэлтийг улирал бүр танилцуулж ажиллах

ҮЗЛЭГЭЭР ХИЙГДЭХ ШИНЖИЛГЭЭ:

- Хэвлийн ЭХО
- Ходоодны дуран
- Зүрхний цахилгаан бичлэг
- Цээж гэрэл харах рентген оношилгоо
- Цусны шинжилгээ
- Шээсний шинжилгээ
- Биохимийн шинжилгээ
- Элэгний В,С вирус илрүүлэх шинжилгээ
- ХДХВ/ДОХ-ын шинжилгээ
- Өтгөнд далд цус илрүүлэх шинжилгээ
- ПАП-ын шинжилгээ

ҮЗЛЭГ

- Мэдрэл
- Дотор
- Эмэгтэйчүүд
- Халдварт
- Зүрх судас

СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЖ, МЭДЛЭГ ОЛГОЖ, ДАДЛЫГ ЭЗЭМШҮҮЛЭХ

- Эрүүл мэндийн боловсрол мэдлэг олгох сургалтуудыг зохион байгуулах
- Ажлын байранд аюулгүй ажиллагааг баримталж, халдварт өртөхөөс сэргийлэх сургалтуудыг зохион байгуулах.
- Аюулгүй байдал, ажлын байран дахь эрсдэлт өртөлт, өртөлтийн дараах арга хэмжээний талаарх сургалт
- Ажлын байрны стрессээс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох сургалт
- Ажилчинд ганцаарчилсан зөвлөгөө өгч ажиллах.

ТАЙЛАГНАХ

- Үзлэгийн зохион байгуулсан, үр дүнг тооцож тайланг улирал бүр байгууллагын удирдлагад танилцуулж удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлж байх
- Нэн шаардлагатай шийдвэрлүүлэх асуудлыг тухай бүр танилцуулж шийдвэрлүүлэх